

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО,  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ХАМТАРСАН ТОГТООЛ/ТУШААЛ

2021 оны 02 дугаар  
сарын 19-ны өдөр

Дугаар 11.А/17

Улаанбаатар  
хот

**Аргачлал батлах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, 29.3.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООН/ТУШААХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалыг хавсралтаар баталсугай.

2.Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга /Д.Баяндүүрэн/, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /О.Тэнгис/ нарт даалгасугай.


МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ  
ХОРООНЫ ДАРГА

  
П.ДЭЛГЭРНАРАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Д.ДАВАА-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

  
Д.ЗАНДАНБАТ



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД НАМ, ЭВСЛЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН  
ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХ АРГАЧЛАЛ**

***Нэг. Нийтлэг үндэслэл***

1.1.Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасан нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо энэхүү аргачлалыг баримтална.

***Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох төлөвлөлтийн үе шат***

2.1.Зардлын дээд хэмжээг тооцоолохын өмнө хийх урьдчилсан судалгаа

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо дараах судалгааг хийсэн байна. Үүнд:

-Хууль, эрх зүйн орчны судалгаа;

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42.9-д заасан цагдаагийн төв байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан Цахим орчныг ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам;

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41.20-д заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам;

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 45.2-т заасан нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, хуульд заасан бусад шаардлагатай мэдээллийг эрх бүхий байгууллагуудаас дэлгэрэнгүй (аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо)-ээр авах:

-Өдөр тутмын сонин гаргадаг болон сэтгүүлийн үйл ажиллагаа эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс хэвлэлийн үнийн санал авах;

-Хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс хэвлэлийн үнийн санал авах;

-Хэвлэлийн үйлдвэрүүдээс гудамж, талбайд байршуулах зурагт самбарын үнийн санал авах;

-Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч гурваас доошгүй этгээдээс үнийн санал авах;

-Цахим орчин ашиглаж сурталчилгаа явуулахтай холбоотой зохих үйл ажиллагаа эрхэлдэг гурваас доошгүй этгээдээс үнийн санал авах;

-Өмнөх ээлжит сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон эрх зүйн акт;

-Өмнөх ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлангийн архивын материал;

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох нам, эвслээс авсан сонгуульд зарцуулах зардлын санал зэрэг болно.

## 2.2.Зардлын дээд хэмжээг тооцоолох дүн шинжилгээний төлөвлөгөө

Нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо дүн шинжилгээ хийх төлөвлөгөө боловсруулсан байна. Төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- дүн шинжилгээ хийх үндэслэл;
- зорилт, хамрах хүрээ;
- эрсдэлийн үнэлгээ;
- шалгуур үзүүлэлт, нотлох зүйлс цуглуулах арга зүй;
- дүн шинжилгээ хийхээр томилсон болон хянан удирдах ажилтан;
- хөтөлбөр;

Зардлын дээд хэмжээ тогтоох дүн шинжилгээ хийх төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчоор батлуулна.

### ***Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал***

#### 3.1.Сонгуулийн сурталчилгаа хийх хоногийг тооцоолох

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-ийг шалгуур болгон тооцоолно.

**Аргачлал:** Сонгуулийн сурталчилгаа хийх хоногийн тоог Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7-д заасан хоногоос 34.1-т заасан зогсоох хоногийг хасаж тогтооно.

Сурталчилгаа хийх хоногийн тоо = 16 хоног - 1 хоног

#### 3.2.Сонгуулийн зардал

Сонгуулийн зардлыг тооцоолохдоо Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 32, 34, 35, 44 дүгээр зүйлийг тус тус үндэслэнэ. Үүнд:

-Сонгууль эрхэлсэн байгууллагатай холбоотой зардлыг тооцно:

- хөлс, урамшуулал;
- томиллт;
- бичиг хэрэг, бусад;

-Сонгуулийн сурталчилгааг явуулах дараах арга, хэлбэр тус бүрээр тооцно:

- сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;
- нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;
- хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж, талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;
- сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;
- ухуулах байр ажиллуулах;
- радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;

- цахим орчин ашиглах;
- өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.

-Сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийн зардлыг тооцно.

### 3.2.1. Сонгууль эрхэлсэн байгууллагын зардал

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4, 32.5 дахь хэсгийг шалгуур болгоно.

#### 3.2.1.1. Хөлс, урамшууллын зардал

**Аргачлал:** Нам, эвслийг төлөөлөн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны хөлс, урамшууллын зардлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т заасныг үндэслэн нам, эвслийг төлөөлөн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий ажилтны тоо, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /ХХДХ/-г харгалзан дараах байдлаар тооцоолно:

- а. улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтны хөлс =  $ХХДХ * 2 * 200$ ;
- б нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтны хөлс =  $ХХДХ * 2 * 100$ ;
- в. аймаг, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтны хөлс =  $ХХДХ * 2 * 50$ ;
- г. сум, хорооны хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтны хөлс =  $ХХДХ * 2 * 20$ .

Нэр дэвшигчийн ерөнхий менежер, менежер, шадар туслагч, ухуулагчийн хөлс, урамшууллын зардлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5-д заасныг болон Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /ХХДХ/-г харгалзан дараах байдлаар тооцоолно:

- а. Ерөнхий менежерийн хөлс =  $ХХДХ * 3$  дахин
- б. Менежерийн хөлс =  $ХХДХ * 3$  дахин
- в. Шадар туслагчийн хөлс = шадар туслагчийн тоо \*  $(ХХДХ * 2)$  дахин
- г. Ухуулагчийн хөлс =  $ХХДХ * 1 * \text{Ухуулагчийн тоо}$

Ухуулагчийн тоог тогтоохдоо эрх бүхий байгууллагаас авсан сонгогчийн тоог харгалзан тооцоолно.

Нам, эвслээс зарцуулах хөлс, урамшууллын нийт зардал нь дээрх хөлс урамшууллын нийлбэр байна.

#### 3.2.1.2. Томилолтын зардал

**Аргачлал:** Томилолтын зардлыг нам, эвслийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах /улсын хэмжээнд ажиллах/ эрх бүхий ажилтны тоо, сонгуулийн сурталчилгааны хоног, Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалаар баталсан албан томилолтын зардлын хэмжээг үндэслэн тооцоолно.

Томилолтын зардал = үйл ажиллагаа явуулах эрх бүхий ажилтны тоо \* нэг хоногт ногдох томилолтын зардал \* сонгуулийн сурталчилгааны хоног

#### 3.2.1.3. Бусад зардал

**Шалгуур:** Өмнөх жилүүдийн нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлээр нийт дүнд материаллаг хувь эзлэхгүй боловч зайлшгүй гарах хэд хэдэн зардал (тухайлбал, бичиг хэрэг, харилцаа холбоо гэх мэт) сонгуулийн сурталчилгаанд гарснаар тайлагнасан байна. Зардлын дээд хэмжээ тогтоох тооцооллыг бодит байдалд нийцүүлэхийн тулд тус зардлыг сонгууль эрхэлсэн байгууллагын зардалд хамааруулан тооцоолно.

**Аргачлал:** Өмнөх ээлжит сонгуулийн нийт зардалд 7-10% эзэлж байна. Иймээс бусад зардал нь нам, эвслийн сонгуулийн нийт зардлын 10%-аас ихгүй байхаар тооцоолно.

$$\text{Бусад зардал} = \text{Сонгуулийн нийт зардал} * \text{бусад зардлын хувь } 7\%-10\%$$

### 3.2.2. Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг шалгуур болгон тооцоолно. Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 32 дугаар зүйлийн 32.4, 32.5 дахь хэсгийг тус тус харгалзан үзнэ.

#### 3.2.2.1. Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал

**Аргачлал:** Нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардлыг дараах аргачлалаар тооцоолно.

Сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдийн сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэх хуудасны тоог гаргана.

№	Хуулийн 36.1 дэх заалт	Хуулийн 36.6 дах заалт	А4 бичгийн цаасны нүүрээр тооцсон хуудасны тоо
1	Гурван хэвлэлийн хуудас сонин	А4 бичгийн цаасны найман нүүр	24 нүүр
2	Гурван хэвлэлийн хуудас сэтгүүл		24 нүүр
3	Нэг хэвлэлийн хуудас ухуулах хуудас		8 нүүр

а. Хэвлэлийн А4 бичгийн цаасны 24 нүүрийг сонин хэвлэлийн гурван компанийн үнийн дунджийн үржвэр, түүнийг өрхийн тоогоор үржүүлсэн дүнгээр зардлыг тооцоолно.

$$\text{Сонин хэвлүүлэх зардал} = 24 \text{ нүүр} * \text{дундаж үнэ}_{\text{сонин хэвлэлийн газар}} * \text{өрхийн тоо}$$

б. Хэвлэлийн А4 бичгийн цаасны 24 нүүрийг сэтгүүл хэвлэн гаргадаг гурван компанийн үнийн дунджийн үржвэр, түүнийг өрхийн тоогоор үржүүлсэн дүнгээр зардлыг тооцоолно.

$$\text{Сэтгүүл хэвлүүлэх зардал} = 24 \text{ нүүр} * \text{дундаж үнэ}_{\text{сэтгүүлийн газар}} * \text{өрхийн тоо}$$

в. Хэвлэлийн А4 бичгийн цаасны 8 нүүрийг хэвлэлийн гурван компанийн үнийн дунджийн үржвэр, түүнийг өрхийн тоогоор үржүүлсэн дүнгээр зардлыг тооцоолно.

Ухуулах хуудас хэвлүүлэх зардал = 8 нүүр \* дундаж үнэ хэвлэлийн газар \* сонгогчийн тоо.

$$\text{Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал} = \text{сонин хэвлүүлэх} + \text{сэтгүүл хэвлүүлэх} + \text{сонгогчдод тараагдах ухуулах хуудас хэвлүүлэх}$$

### 3.2.2.2. Сонгуулийн сурталчилгааны материал тараах зардал

**Аргачлал:** Нам, эвслээс сонгуулийн сурталчилгааны материалыг аймаг, сум, дүүргийн сонгуулийн хэсэгт хүргүүлэх зардлыг шуудангаар хүргүүлнэ гэж тооцно.

Шуудангийн хүргэлтийн зардал = сурталчилгааны материалын жин \* шуудан хүргэлтийн үнэ.

3.2.3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардал

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн холбогдох заалтыг шалгуур болгон тооцоолно.

**Аргачлал:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т зааснаар зурагт самбар хэвлүүлэх зардлыг тооцох бөгөөд үүнд байрлуулах зардал хамаарахгүй.

а. гудамж, талбайд байрлуулах зурагт самбар хэвлэх үнийн судалгааг гурваас доошгүй хэвлэлийн үйлдвэрүүдээс авч дундаж үнийг тооцно.

б. сонгуулийн хэсгийн тоог хуулийн 11.1 дүгээр зүйлд үндэслэн тооцоолж, хуулийн 37.1-т заасан тоогоор үржүүлж нийт зурагт самбарын тоог гаргана.

Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах нийт зардал = зурагт самбар хэвлүүлэх дундаж үнэ \* нийт зурагт самбарын тоо

3.2.4. Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь хэсгийг тус тус шалгуур болгон, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 35 дүгээр зүйлийн 35.1, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг харгалзан тооцоолно.

**Аргачлал:** Намын далбааг хэвлүүлэх зардал нь хуулиар зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл тус бүрт 2, ухуулах байранд 3 тус тус байхаар дараах байдлаар тооцно. Намын далбаа хэвлүүлэх үнийн дунджийг уг үйл ажиллагаа эрхлэгч гурваас доошгүй этгээдээс авсан үнийн саналын дундаж байна.

а. Тээврийн хэрэгсэлд ашиглах намын далбаа = нийт тээврийн хэрэгслийн тоо \* 2 \* дундаж үнэ

б. Ухуулах байранд ашиглах намын далбаа = ухуулах байрны тоо \* 3 \* дундаж үнэ

Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах нийт зардал = (а+б)

3.2.5. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, 39.3 дахь хэсгийг тус тус шалгуур болгон тооцоолно.

**Аргачлал:** Өмнөх ээлжит сонгуульд нам, эвслүүдээс зарцуулсан тухайн зардлын гүйцэтгэлийн нийлбэр дүнг нийт зардал гаргасан нам, эвслүүдийн тоонд

хувааж гарсан дундаж дүнг сүүлийн 3 жилийн Улсын инфляцын өсөлттэй уялдуулан тооцно. Нам, эвслээс авсан уулзалт, хурал, цуглаан хийх зардлын саналыг харгалзан үзэж болно.

Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх нийт зардал = өмнөх сонгуулийн зардлын дундаж дүн \* инфляцын өсөлт<sub>3 жилээр</sub>

### 3.2.6. Ухуулах байр ажиллуулах зардал

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсгийг тус тус шалгуур болгон, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг харгалзан тооцоолно.

**Аргачлал:** Ухуулах байрыг ажиллуулах хугацаа нь сонгуулийн сурталчилгаа хийх хугацаатай ижил байна. Нэг ухуулах байрны түрээслэх зардлыг 1 сар байхаар тооцно.

а. Ухуулах байрны тоог хуулийн 11.3-т заасан хэсгийн тоог үндэслэнэ.

б. Байрны түрээсийг орон нутаг, нийслэлд ялгаатай тогтоох бөгөөд зах зээлийн үнэ ханшийг харгалзан тогтооно.

Ухуулах байр ажиллуулах зардал = ухуулах байрны тоо \* ухуулах байрны түрээсийн зах зээлийн дундаж үнэ /1 сараар/

### 3.2.7. Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг шалгуур болгон тооцоолно.

**Аргачлал:** Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн сурталчилгаа нэвтрүүлэх зардлыг тогтоохдоо сурталчилгааны контент, шторкийн эх бэлтгэл, сурталчилгаа нэвтрүүлэх зардлыг тус тус тооцож тогтооно.

а. сурталчилгааны контент, шторкийн эх бэлтгэлийн үнийг Харилцаа холбооны зохицуулах хороонд сонгуулийн сурталчилгаа явуулахаар бүртгүүлсэн улсын хэмжээний 3 радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийн үнийн саналын дунджаар тооцно.

Эх бэлтгэлийн зардал = дундаж үнэ \* хугацаа

б. сурталчилгаа нэвтрүүлэх зардлын дундаж үнийг 3 радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийн үнийн саналын дунджаар тооцно.

в. сурталчилгаа нэвтрүүлэх зардлын хэмжээг тогтоохдоо сурталчилгаа нэвтрүүлэх зардлын дундаж үнэ, нам эвсэлд ногдох хугацаа, сонгуулийн сурталчилгааны /15/ хоногийн үржвэрийг өдөрт 5-аас цөөнгүй радио, телевизийн үржвэрээр тооцно.

Нэвтрүүлгийн зардал = (дундаж үнэ \* нам, эвсэлд ногдох мин \* 15хоног) \* радио, телевизийн байгууллагын тоо.

Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах нийт зардал = эх бэлтгэлийн зардал + нэвтрүүлгийн зардал

### 3.2.8. Цахим орчин ашиглах

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг шалгуур болгоно.

**Аргачлал А:** Нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудаст шаардагдах зардлын дээд хэмжээг тогтоохдоо дараах 4 төрлийн зардлын дунджийн нийлбэрээр тооцно. Үүнд:

Цахим орчин ашиглах зардал = домайн нэр + контент бэлтгэх + цахим хуудас хөгжүүлэх + хостинг

а. домайн нэр /Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.15<sup>1</sup>-д заасныг ойлгоно./ худалдан авах зардлыг тооцохдоо тус чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг 3 компаниас домайн нэр худалдах үнийн саналыг авч, дундаж үнийг гаргана.

б. Контент бэлдэх зардлыг зорилтот сегмент буюу сонгогчдод сурталчилгаа хүргэх хэрэгцээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг баримтлан контент бүтээгч 3 компаниас үнийн саналыг авч дунджаар тооцох бөгөөд хуулийн 41, 42.1.2-т заасан сурталчилгааны эх бэлтгэлийн зардалтай уялдуулж тооцно.

в. Программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 компаниас цахим хуудас хөгжүүлэх үнийн саналыг авч, дунджаар тооцно.

г. Монгол Улсад хостингийн<sup>2</sup> үйлчилгээ үзүүлдэг 3 компаниас 1 сарын хугацаанд вэб сервер түрээслэх үнийн санал авч, дунджаар тооцно.

**Аргачлал Б:** Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудаст шаардагдах зардлын дээд хэмжээг тогтоохдоо дараах 2 төрлийн зардлын дунджийн нийлбэрээр тооцно. Үүнд:

Зардал = Идэвхжүүлэлтийн зардал + Контент бэлтгэх зардал

а. Нам эвсэл нь олон нийтийн сүлжээний цахим хуудсанд идэвхжүүлэлт хийхэд гарах зардлын хэмжээг тооцохдоо улсын хэмжээний нийт сонгогчдын тоотой тэнцүү хэрэглэгчдэд сонгуулийн сурталчилгааны хугацаанд идэвхжүүлэлт хийх зардлын хэмжээгээр тогтооно. Уг хэмжээг тогтоохдоо тухайн олон нийтийн сүлжээний цахим хуудасны өөрийн тооцоолуурыг ашиглан тогтооно.

б. Нэр дэвшигчийн хувьд олон нийтийн сүлжээний цахим хуудсанд идэвхжүүлэлт хийхэд гарах зардлын хэмжээг тооцохдоо тухайн тойргийн нийт сонгогчдын тоотой тэнцүү хэрэглэгчдэд сонгуулийн сурталчилгааны хугацаанд идэвхжүүлэлт хийх зардлын хэмжээгээр тогтооно. Уг хэмжээг тогтоохдоо тухайн олон нийтийн сүлжээний цахим хуудасны өөрийн тооцоолуурыг ашиглан тогтооно.

в. Контент бэлдэх зардлыг зорилтот сегмент буюу сонгогчдод сурталчилгаа хүргэх хэрэгцээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг баримтлан контент бүтээгч 3 компаниас үнийн саналыг авч, дунджаар тооцох бөгөөд хуулийн 41, 42.1.2-т заасан сурталчилгааны эх бэлтгэлийн зардалтай уялдуулж тооцно.

**Аргачлал В:** Бусад цахим хуудсыг сурталчилгаанд ашиглах нам, эвсэл болон нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг тогтоохдоо дараах байдлаар тооцно.

Хамгийн их хандалттай<sup>3</sup> 3 цахим хуудаснаас мэдээ болон баннер байршуулж байсан үнийн саналыг авч 1 өдрийн турш байршуулах үнийн дунджийг гаргах бөгөөд

<sup>1</sup>“домэйн нэр” гэж интернэтийн нөөцийн хаягийг тодорхойлох тухайн улсад тусгайлан олгосон үсэг, тоо, бусад таних тэмдгийн хослолыг /Жишээ нь: [www.google.com](http://www.google.com), [www.audit.mn/](http://www.audit.mn/)

<sup>2</sup>Цахим хуудсыг интернэтэд байрлуулах вэб серверээр хангах үйлчилгээ

сегмент буюу сонгогчдод сурталчилгаа хүргэх хэрэгцээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг баримтлан тооцно.

3.2.9.Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.8 дугаар зүйлийг тус тус шалгуур болгон тооцоолно.

**Аргачлал:** Өдөр тутмын болон бусад 3-аас доошгүй сонин сэтгүүл эрхлэн гаргагчийн үнийн саналын дунджаар тооцно.

Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх зардал = 24 нүүр \* дундаж үнэ<sup>3</sup><sub>хэвлэлийн газар</sub>

3.2.10.Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах зардал

**Шалгуур:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийг шалгуур болгоно. Мөн Зам тээврийн, хөгжлийн сайдын 2019.12.30-ны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1, 3 дугаар хавсралтыг үндэслэнэ.

**Аргачлал:** Ашиглах авто машины марк, түүний 100 км-т зарцуулах шатахууны хэмжээг Зам тээврийн, хөгжлийн сайдын 2019.12.30-ны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1, 3-р хавсралтыг харгалзан тооцно.

Шатахууны үнийг нийслэл болон орон нутаг дах жижиглэнгийн борлуулалтын дундаж үнээр тооцно.

Нэг тээврийн хэрэгслийн өдөрт туулах замын хэмжээг нийслэл болон орон нутаг өдөрт дунджаар 80 км, сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагаас ашиглах тээврийн хэрэгслийн тоог нутаг дэвсгэрийн хэмжээ, байршилд нийцүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д зааснаар тус тус тооцно.

Тээврийн хэрэгслийн зардал = Шатахууны үнийн дундаж \* 1 өдөрт зарцуулах шатахууны хэмжээ \* 15 хоног \* Тээврийн хэрэгслийн тоо /Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан/

---oOo---

---

<sup>3</sup>Хандалтын хэмжээг тогтоохдоо <https://www.alexa.com/topsites/countries/MN> линкийг ашиглах боломжтой